

“Бэрх Уул” ХК-ны 2015 оны үйл ажиллагааны тайлан

Үнэт цаас гаргагчийн нэр, оршин суугаа хаяг:

Компанийн нэр: ”Бэрх Уул” ХК
Хаяг: Хэнтий, Өлзийт, Бэрх тосгон /Батноров/, Үйлдвэрийн байр-1
Утас: 99092755

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэл:

Улсын бүртгэлд бүртгэсэн огноо: 2006.12.14
Улсын бүртгэлийн дугаар: 1810002001
Регистрын дугаар: 2643928
Үйл ажиллагааны чиглэл: Нүүрс, жонш олборлолт
Хувьцаа эзэмшигчдийн тоо: 19,062,080

1. Боловсон хүчин

Тус компани нь 2015 оны жилийн эцсийн байдлаар нийт 33, үүнээс Захиргааны хэсэгт 11, Чандганы хэсэгт 8, Харуулын хэсэгт 14 ажиллагсадтай хөдөмөрийн гэрээ байгуулан ажиллаж байна. Нийт ажиллагсадын 19 эмэгтэй, 14 эрэгтэй. Мөн энгийн групптэй 2, мэргэжлээс шалтгаалах өвчний групптэй 2, өндөр насны тэтгэвэртэй 4 хүн ажиллаж байна. Компанийн захиргаа, Үйлдвэрчний эвлэлийн хооронд 2015-2016 онд хэрэгжүүлэх хамтын гэрээний 2015 оны биелэлт 92.1%-ийн биелэлттэй дүгнэгдсэн. Тайлант онд Гүйцэтгэх захиралын 65 тушаал гарсанаас боловсон хүчний талаар 53, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 9, бусад асуудлаар 3 тушаал тус тус гарсан. Мөн байгууллагын архиваас лавлагаа авах 102 захиалгын дагуу 96 архивын лавлагаа олгосон.

2. Нүүрс олборлолт

2015 онд Чандганы нүүрсний уурхайд 128300 м³ хөрс хуулж, 25000 тонн нүүрс олборлон борлуулах төлөвлөгөөтэй байснаас 133500 м³ хөрс хуулж, 29400 м³ хөрс цэвэрлэгээний ажлыг нэмж гүйцэтгэн Хэнтий аймгийн болон бусад сумдын хэрэглэгчдийн хэрэгцээнд 33031.5 тонн нүүрс олборлон борлуулалт хийсэн.

Өнгөрсөн жилийн хувьд хөрс хуулалтын ажлыг 7-р сарын 25-аас 10-р сарын 01-ны хооронд гүйцэтгэхээр төлөвлөсөн хэдий ч зарим аж ахуйн нэгж, байгууллагууд төсөвт суусан халаалтын зардал дууссан, төсөвт байгууллагаас авах халаалтын авлагаа авч чадахгүй

байна гэдэг тайлбартайгаар 7-р сарын 25-ны байдлаар нэлээдгүй хэмжээний өртэй гарсан. Иймээс 2015 оны уулын ажлын төлөвлөгөө ёсоор хөрс хуулалтын ажлыг 7-р сард эхлэх байсан хэдий ч дээрхи авлагын асуудлаас болоод 2015-2016 оны халаалтын улиралд ажиллах техникийн урсгал засварын ажил болон хөрс хуулалтын ажил төлөвлөгөөний дагуу эхэлж чадахгүйд хүрсэн.

Дээрхи аж ахуйн нэгж, байгууллагуудаас авлагаа цаг тухайд нь авч чадаагүйн улмаас техникүүдийн урсгал засвар болон хөрс хуулалтын ажил хойшлогдож, орон нутгийн өвөлжилтын байдалд хүндрэл учрах эрсдэлтэй байсан тул хөрөнгө оруулагчдаас зээл авч, 2.8-3.2 м³-ын шанагатай 2 ширхэг эксковатор, 14-17 м³-ын тэвшний багтаамжтай 6 ширхэг Howo, Steyr маркын автосамосвалуудыг түрээслэн хөрс хуулалтын ажлыг 9-р сарын 5-нд эхэлж, 10-р сарын 25-нд дууссан.

Тайлант онд уурхайн гол техникүүд болох KOMATSU-D155A бульдозер, DOOSAN эксковаторт урсгал засвар, ZL50C-автоачигчийн моторт их засварын ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

Чандганы нүүрсний уурхайн 2015 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хүрээнд 12.68 сая төгрөг зарцуулна гэж төлөвлөснөөс 10.01 сая төгрөг зарцуулан ажилласан.

Энэ ажлын хүрээнд дараах ажлуудыг хийсэн.

- Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө: Агаар, хөрс, усны шинжилгээг мэргэжлийн байгууллагаар хийлгэн байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатай байлгах талаар арга хэмжээ авсан ба үүнд нийт 0.33 сая. Мөн уурхайгаас засмал зам хүртэлх 50-60 м-ийн өргөнтэй, 5 км газрын цэвэрлэгээнд 2 техникт 350 литр түлш зарцуулан, 8 хүн, 4 өдөр ажиллаж мөрөн сумын газрын даамал Ө.Өнөрөөд хүлээлгэн өгч холбогдох баримтыг гаргуулсан ба энэ ажилд 1.55 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байснаас 1.46 сая төгрөг зарцуулан ажилласан.
- Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө: Чандганы нүүрсний уурхайн хувьд нийт 43.75 га талбайг хамрах бөгөөд 2012 онд хийгдсэн ТЭЗҮ-д тусгагдсанаар нөөц шавхагдаагүй, цаашид ашиглах их хэмжээний нөөц уурхайн ухааш дор, усанд эзлэгдэн байгаа тул уг уурхайн хувьд зөвхөн шимт хөрс хуулах, хадгалах ажлыг гүйцэтгэх ба бусад техник болоод биологийн нөхөн сэргээлтийн ажил хийгдэхгүй гэсэн шийдэлтэй явдаг. Үүний дагуу 2015 онд 3680 м³ шимт хөрсийг тусад нь хуулж, овоолго үүсгэн хадгалж байна. Энэ ажилд 5.9 сая төгрөг зарцуулахаар төлөвлөсөн байснаас 3.15 сая төгрөг зарцуулан ажилласан ч энэ зардлыг хөрс хуулалтын зардалд тооцдог.
- Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө: Ахуйн болон аюултай хаягдлыг компанийн дотоод журмын дагуу ангилан ялгалтын ажлыг сайжруулан, дахин

ашиглалтын хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор ахуйн гаралтай болон засварын газраас гарах тостой хог хаягдал, тосолгооны материал, цэвэрлэгээний уусмал, өдөр тутмын үзлэг тосолгооноос гарсан хог хаягдлууд зэргийг ялган тусгаалах савыг нэмж байрлуулсан. Энэ ажилд 0.35 сая төгрөг зарцуулах төлөвлөснөөс 0.1 сая төгрөг зарцуулан ажилласан.

- Уурхайг тохижуулах, тосгон орчимд хийгдэх ажлын төлөвлөгөө: Уурхайн эдэлбэр газрыг ойжуулах, цөлжилт хурдацтай явагдаж байгаагаас сэргийлэх зорилгоор “Биндэр ой, сум дундын ойн анги, орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар”-аас 2013 оноос хойш улиас хайлаасны суулгацыг өөрийн компанийн зардлаар авчран тарьж байна. 2015 онд 0.5 га талбайд 1000 ширхэг улиасны суулгац тарьж ургалт, өсөлтөд нь анхааран ажиллаж байгаагаас одоогоор 81%-ийн ургалттай байна. Энэ ажилд 3.0 сая төгрөг зарцуулан ажиллах төлөвлөгөөтэй байснаас 7.7 сая төгрөг зарцуулан ажилласан.
- Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах талаар сургалт, семинар зохион байгуулах төлөвлөгөө: Мөрөн сумын ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан ба Чандганы уурхайн ажилчид, тус багийн малчид идэвхитэй оролцсон. Сургалтанд нийт 25 хүн хамрагдсан. Энэ ажлын хүрээнд 0.6 сая төгрөг зарцуулах төлөвлөгөөтэй байснаас 0.42 сая төгрөг зарцуулан ажилласан.

3.Санхүү

Компанийн 2015 оны жилийн орлого үр дүнгийн тайлан:

2015 оны байдлаар 33,031.5 тн нүүрс борлуулж 695,73 сая төгрөгийн орлого, ББӨ 618,27 сая төгрөг, үйл ажиллагааны зардалд 2,296.12 сая төгрөг, үйл ажиллагааны бус алдагдал буюу долларын ханшийн зөрүүний алдагдал нь (714.24) сая төгрөг болж, нийт энэ онд (2,933.01) төгрөгийн алдагдалтай ажилласан.

Компаний үйл ажиллагааны зардал 2,296.12 сая төгрөгийн зардлыг ерөнхийд нь задалж үзэхэд:

1. Ерөнхий удирдлагын зардал 560,27 сая төгрөг
2. Зээлийн хүүгийн зардал 1735,85 сая төгрөг

Орлого үр дүнгийн тайлан	Хэмжих нэгж	2014 он	2015 он
Борлуулалт	сая. төг	605.29	695.73
Борлуулалтын хөнгөлөлт	сая. төг		
Цэвэр борлуулалт	сая. төг		
ББӨ	сая. төг	497.14	618.27
Нийт ашиг	сая. төг	108.15	77.46
Үйл ажиллагааны зардлын дүн	сая. төг	2,484.38	2,296.12
Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	сая. төг	(2,376.23)	(2,218.66)
Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	сая. төг	(1,956.42)	(714.24)
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	сая. төг	(4,332.65)	(2,932.89)
Орлогын татварын зардал	сая. төг	108.06	0.12
Татварын дараах ашиг (алдагдал)	сая. төг	(4,440.71)	(2,933.01)

Чандганы нүүрсний уурхайн хэсэг:

2015 онд Чандганы нүүрсний уурхайд хөрс хуулалтын ажлыг “Юнайтед транс” ХХК-р амжилттай гүйцэтгүүлсэн. Нүүрсний борлуулалт болон борлуулсан бүтээгдэхүүний өртөг, ашиг алдагдлыг сүүлийн 3 жилээр тооцож үзвэл:

№	Төрөл	Хэмжих нэгж	2013	2014	2015
1	Нүүрсний борлуулалт тн	Тн	18,692.5	28,775.0	33,031.5
2	Нүүрсний борлуулалт үнэ	сая. төг	393.04	605.29	695.73
3	ББӨ	сая. төг	339.06	497.14	618.27
4	Нийт ашиг	сая. төг	53.98	108.15	77.46

Компанийн 2015 оны жилийн баланс :

Компанийн 2015 оны жилийн балансад богино хугацаат болон урт хугацаат өр төлбөр өссөн. Энэ нь 2015 онд өмнө авсан байсан зээлийн гэрээний хугацааг сунгахад зээлийн хүүг өсгөсөн, мөн энэ онд KHANATE RESOURCE HOLDING-3 SARL –аас 400,000 \$- н зээлийг авсантай холбоотойгоор нийт өр төлбөр өссөн. Мөн үүнээс гадна 2015 онд долларын ханш өссөн нь санхүүгийн тайланд долларын зээл болон зээлийн хүүгийн зардлын дүнг өсгөж байна.

/сая.төг/			
№	Баланс	2014.12.31	2015.12.31
1	ХӨРӨНГӨ:		
2	Эргэлтийн хөрөнгө	118.44	327.59
3	Эргэлтийн бус хөрөнгө	11,939.53	12,243.23
4	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	12,057.96	12,570.82
5	ӨР ТӨЛБӨР:		
6	Богино хугацаат өр төлбөр	3,826.66	5,831.47
7	Урт хугацаат өр төлбөр	24,874.84	26,315.91
8	ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН:	28,701.51	32,147.37
9	ЭЗДИЙН ӨМЧ		
10	Хувийн өмч	1,906.21	1,906.21
11	Хуримтлагдсан ашиг	(18,549.75)	(21,482.76)
12	ЭЗДИЙН ӨМЧИЙН НИЙТ ДҮН	(16,643.54)	(19,576.55)
13	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	12,057.96	12,570.82

2015 оны татвар, нийгмийн даатгалын шимтгэлд:

Компани нь санхүүгийн тайлан балансыг хуульд заасан хугацаанд цаг тухайд нь гаргаж аж ахуй нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, үл хөдлөх хөрөнгийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, агаарын бохирдлын төлбөр болон нийгмийн даатгалын тайланг хуульд заасан цаг хугацаанд нь өгч байгаа.

2015 онд татварт 81,1 сая төгрөг төлж 92,6 сая төгрөгийн өртэй, мөн нийгмийн даатгалын шимтгэлд 66,6 сая төгрөг төлж 63,9 сая төгрөгний өртэй гарсан.

/мян.төгрөг/					
№	Татварын төрөл	Эхний үлд	Үүссэн татвар	Төлсөн дүн	Үлдэгдэл
1	АМНАТатвар	3,486.65	17,393.29	14,402.92	6,477.02
2	Агаарын бохирдолын төлбөр	5,114.80	16,443.75	15,440.80	6,117.75
3	ХАОАТатвар	13,393.68	41,293.40	30,104.21	24,582.87
4	Суутган тооцсон албан татвар	16,502.31	534.88	15,537.37	1,499.82
5	НӨАТатвар	39,485.84	15,516.23	1,000.00	54,002.07
6	Үл хөдлөх хөрөнгийн татвар		3,281.45	3,281.45	-

7	Авто тээврийн татвар		655.00	655.00	-
8	Бууны татвар		32.00	32.00	-
9	Газрын төлбөр		541.74	541.74	-
10	АНОАТатвар	(3,318.67)	115.05	115.05	(3,203.62)
11	АТӨЯХАБ		43.00	43.00	-
12	Нийгмийн даатгалын шимтгэл	40,467.58	90,102.42	66,614.73	63,955.28
Нийт		115,132.18	185,952.22	147,768.27	153,431.19

Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан түшаалтны танилцуулга:

№	Овог нэр	Албан тушаал	Боловсрол	Ажлын туршлага
1	Б.Батбаатар	ТУЗ-ийн дарга	Дээд	Шарын гол ХК-ийн Гүйцэтгэх захирал
2	Жэймс Пассин	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Файрбөд сангийн үүсгэн байгуулагч
3	Б.Мэндсайхан	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Бэрх Уул ХК-ийн гүйцэтгэх захирал
4	Б.Пүрэвбаатар	ТУЗ-ийн гишүүн	Дээд	СиБиЭм ХХК-ийн БХА дарга
5	Д.Даянбилгүүн	ТУЗ-ийн гишүүн	Дээд	БиДиСек ХК-ийн гүйцэтгэх захирал
6	Б.Лхагвадорж	ТУЗ-ийн гишүүн	Дээд	БиДиСек ХК-ийн тэргүүн дэд захирал
7	Д.Нарангоо	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Үнэмлэхүй эрх ХХК-ийн гүйцэтгэх захирал
8	Б.Батхуяг	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Хэрлэн Онон Туул ББСБ гүйцэтгэх захирал
9	Б. Батмөнх	ТУЗ-ийн гишүүн	Дээд	Шарын гол ХК-ийн ТУЗ дарга

Үнэт цаас гаргагчийн ТУЗ, дэд хороодын үйл ажиллагааны тайлан, цалин урамшууллын хэмжээ, үнэт цаас эзэмшдэг талаархи мэдээлэл:

№	Овог нэр	Хараат бус гишүүн эсэх	Эзэмшиж байгаа хувьцааны тоо хувь	Цалин урамшууллын хэмжээ
1	Б.Батбаатар	Энгийн	эзэмшдэггүй	0₮
2	Жэймс Пассин	Энгийн	эзэмшдэггүй	0₮
3	Б.Мэндсайхан	Энгийн	эзэмшдэггүй	4,000,000₮
4	Б.Пүрэвбаатар	Энгийн	эзэмшдэггүй	0₮
5	Д.Даянбилгүүн	Энгийн	эзэмшдэггүй	0₮
6	Б.Лхагвадорж	Энгийн	эзэмшдэггүй	0₮
7	Д.Нарангоо	Хараат бус	эзэмшдэггүй	0₮
8	Б.Батхуяг	Хараат бус	эзэмшдэггүй	0₮
9	Б. Батмөнх	Хараат бус	эзэмшдэггүй	0₮

Компанийн хяналтын багц эзэмшигчийн мэдээлэл

№	Овог нэр	Хувьцааны хувь
1	Khanate Resource Holdings	51,82%
2	Khanate Resource Holdings -2 SARL	31,25%
3	Khanate Resource Holdings-3 SARL	6,58%
4	BEU Holdings SARL	10%

Ногдол ашгийн талаархи мэдээлэл:

Компани нь 2015 онд алдагдалтай ажилласан тул ногдол ашиг тараахгүй тухай шийдвэрийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн 100% саналаар баталсан.

Компанийн тухай хуулийн 87,89 дүгээр зүйлд заасан их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийсэн эсэх талаархи мэдээлэл

Компани их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэлийг Компанийн тухай хуулийн 88.1, 89.1 дугаар зүйлийн дагуу хийсэн.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

Компаний хувьцаа эзэмшигчдийн 2015 оны ээлжит хурлыг хуульд заасан хугацаа, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн “Бэрх Уул” ХК 2015 оны 04 сарын 23-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2015 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2015 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Хурлаар хэлэлцсэн асуудлуудыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар баталсан.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд 2015 оны 04 сарын 23-ны өдөр Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

А. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх аудитын дэд хорооны даргаар **Б.Батмөнх**, гишүүдээр **Д.Даянбилгүүн**, **Д.Нарангоо** нарыг томилсон.

Б. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын дэд хорооны даргаар **Жэймс Пассин**, гишүүдээр **Б.Батмөнх**, **Д.Нарангоо** нарыг томилсон.

В. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар **Б.Батбаатар**, гишүүдээр **Б.Батхуяг**, **Б.Батмөнх** нарыг томилсон.

Компани нь 2014 оны 4 сарын 21-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2013 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2014 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2014 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Компани нь 2013 оны 4 сарын 30-ны Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулснаар дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. ТУЗ-ын гишүүд томилох
2. 2012 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланг батлах
3. 2013 оны бизнес төлөвлөгөө болон төсөв батлах
4. ТУЗ-ын 2013 оны төсөв батлах
5. Хувьцааг хуваах